



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/506

Арвайхээр

**Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын  
зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.9 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 181 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэл сунгасугай.

2.Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан аймгаас орох, гарах, сум хоорондох, баг хооронд эрүүл мэндийн үйлчилгээ авах, буяны үйл ажиллагаа, хүнс, мал мах, шатахуун, нүүрс тээврээс бусад бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэл түр зогсоосугай.

3.Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны жагсаалтыг хавсралтаар баталж, бусад бүх төрлийн хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэр, үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосугай.

4.Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 хүртэл хугацаанд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101127

Аймгийн Засаг даргын 2020 оны...<sup>11</sup>...  
дүгээр сарын ...<sup>16</sup>...-ны өдрийн ...<sup>А/506</sup>...  
дугаар захирамжийн хавсралт



ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХГҮЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ

1.	Орон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа
2.	Эрчим хүчээр хангах үйл ажиллагаа
3.	Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн үйл ажиллагаа
4.	Шатахуун, түлшний /нүүрс, мод/ хангамж, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа
5.	Төв суурин газрын дулаан, ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын үйл ажиллагаа
6.	Эрүүл мэндийн байгууллага, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх үйл ажиллагаа
7.	Банкны төлбөр, тооцооны үйл ажиллагаа
8.	Хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн үйл ажиллагаа
9.	Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа
10.	Шүүх, прокурорын үйл ажиллагаа
11.	Оршуулгын үйл ажиллагаа



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 16 өдөр

Дугаар А/506

Арвайхээр

**Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын  
зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.9 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 181 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэл сунгасугай.

2.Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан аймгаас орох, гарах, сум хоорондох, баг хооронд эрүүл мэндийн үйлчилгээ авах, буяны үйл ажиллагаа, хүнс, мал мах, шатахуун, нүүрс тээврээс бусад бүх төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэл түр зогсоосугай.

3.Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны жагсаалтыг хавсралтаар баталж, бусад бүх төрлийн хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэр, үйлчилгээ, олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосугай.

4.Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 06:00 хүртэл хугацаанд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.


5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ

011101127

Аймгийн Засаг даргын 2020 оны...<sup>11</sup>...  
дүгээр сарын ...<sup>16</sup>...-ны өдрийн ...<sup>А/506</sup>...  
дугаар захирамжийн хавсралт



ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХГҮЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖАГСААЛТ

1.	Орон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа
2.	Эрчим хүчээр хангах үйл ажиллагаа
3.	Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, түгээлтийн үйл ажиллагаа
4.	Шатахуун, түлшний /нүүрс, мод/ хангамж, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа
5.	Төв суурин газрын дулаан, ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын үйл ажиллагаа
6.	Эрүүл мэндийн байгууллага, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх үйл ажиллагаа
7.	Банкны төлбөр, тооцооны үйл ажиллагаа
8.	Хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, шуудангийн үйл ажиллагаа
9.	Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагаа
10.	Шүүх, прокурорын үйл ажиллагаа
11.	Оршуулгын үйл ажиллагаа